

Нийгмийн Даатгалын Тогтолцоонд Хамаарах

Таны гэр бүлийн гишүүд аль нэгэн компанид ажилладаг уу?

Тийм

Үгүй

◆ Ажил олгогч нь таныг "эрүүл мэндийн даатгалд болон тэтгэвэр олгуулах" тогтолцоонд хамруулах үүргийг хүлээнэ. Ажил олгогчоосоо ёс журмын дагуу даатгалд хамруулах арга хэмжээ авахыг хүснэ үү.

[Жич] Хэрэв та албан байгуулагадаа ажлын бүтэн биш өдөр эсвэл түр хугацаагаар ажил эрхэлдэг бол Японы нийгмийн даатгалын тогтолцооны журмаар таныг "компанийн албан бус түр ажилтан" гэж авч үзнэ. Энэ талаар өөрийнхөө компани руу хандаж шалгуулна уу.

◆ Хэрэв танай компани таныг эрүүл мэндийн ба тэтгэврийн даатгалын тогтолцоонд хамруулах талаар зохих ёсны арга хэмжээ авахгүй байвал, энэ талаар өөрт ойр байрлах Японы Тэтгэврийн Үйлчилгээний Салбар Оффист (JPS) хандаж мэдэгдэнэ үү.

◆ Та эрүүл мэндийн даатгал ба тэтгэврийн тогтолцоонд хамрагдахын тулд бүртгүүлэх шаардлагатай. Та өөрийн хотын захиргаанд байрлах Үндэсний Эрүүл Мэндийн Даатгал болон Үндэсний Тэтгэврийн хэлтэст очиж мэдээлэл авна уу.

[Жич] Энэхүү хувилбарт японы оюутнуудаас бусад ажилгүй хүн эсвэл бүтэн ажлын бус өдрүүдэд долоо хоногт 28 цаг ба түүнээс бага хугацаагаар ажилладаг оюутнууд орно.

★ Илүү тодорхой мэдээлэл авахыг хүсвэл, та өөрийн хотын захиргааны Үндэсний Эрүүл Мэндийн Даатгалын болон Үндэсний Тэтгэврийн албанд хандана уу.

Хэрэв та 75 настай эсвэл үүнээс дээш настай бол та 75 нас эсвэл үүнээс дээш насныханд зориулсан Эрүүл Мэнд Халамжлах Тогтолцоонд хамрах эрхтэй. (*Koki Koreisha Iryo Seido*).

★ Илүү тодорхой мэдээлэл авахыг хүсвэл та өөрийн хотын захиргаанд хандана уу: 75 ба түүнээс дээш насныхны асуудлыг хариуцсан Эрүүл Мэндийн Халамжийн алба.

◆Та улсын эрүүл мэндийн даатгал болон тэтгэвэрийн аль нэг халамжийн тогтолцоонд хамрагдаж бүртгүүлэх шаардлагатай.

1. Ажилчдын Эрүүл Мэндийн Даатгалын Тогтолцоо

Хэрэв та даатгасан ажлын байранд* ажилладаг бол таныг яс үндэс харъяаллыг харгалзахгүйгээр Ажилчдын Эрүүл Мэндийн Даатгалын тогтолцоонд хамруулна. Ажилчдын Эрүүл Мэндийн Даатгал нь та болон танай гэр бүлд аливаа өвчин зовлон, бэртэл гэмтэл, хүүхэд төрөх болон хүн нас барсан тохиолдолд даатгал олгож байх тогтолцоо юм.

* НОJIN корпорацид харъяалагддаг болон тав буюу түүнээс илүү орон тооны ажилчидтай (үүнд үсчин, зочид буудал болон ресторануудаас бусад) хувийн ажлын байр бол даатгалд хамрагдсан ажлын байранд орно.

2. 75 нас ба үүнээс дээш насныханд зориулсан Үндэсний Эрүүл Мэндийн Даатгалын тогтолцоо ба Эрүүл Мэндийн тусламж (Koki Koreisha Iryo Seido)

Хэрэв та Япон улсын иргэн биш Цагаачлалын Алба-наас гурван сараас дээш хугацаанд тус улсад байнгын оршин суух эрхтэй, (Үүнд: Таны оршин суух статусаас хамаарч гурван сараас илүү хугацаагаар оршин суух хүмүүс орно.), мөн түүнчлэн Японд оршин суух зөвшөөрөлтэй хүмүүс улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд доор заасны дагуу бүртгүүлэх шаардлагатай;

(1) Хэрэв та 75 наснаас доош настай ба өөр нэгэн эрүүл мэндийн даатгалгүй бол та Үндэсний Эрүүл Мэндийн Даатгалын тогтолцоонд хамрах эрхтэй.

(2) Хэрэв та 75 настай ба үүнээс дээш настай бол 75 нас ба үүнээс дээш насныханд зориулсан Эрүүл Мэндийн Даатгалд хамрах ёстой.

Энэхүү эрүүл мэндийн/эмнэлгийн тусламжийн даатгалын тогтолцоогоор үйлчлүүлсэнээр өвчин тусах болон гэмтэл бэртэл авах тохиолдолд танд тусламж үзүүлэх болно.

[Жич] Та эмнэлэг ба клиникуудаас ашиг олохын тулд Ажилчдын Эрүүл Мэндийн даатгал, Үндэсний Эрүүл Мэндийн Даатгал ба өөрийн эрүүл мэндийн гэрчилгээг эсвэл 75 наснаас дээш насны Эмнэлгийн Тусламжийн картаа үзүүлэх ёстой. Хэрэв гэрчлэх баримт бичиг байхгүй бол та бүх эмчилгээний зардлаа өөрөө дааж төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

3. Ажилчдын Тэтгэврийн Даатгалын тогтолцоо ба Үндэсний Тэтгэврийн Даатгалын тогтолцоо

Хэрэв та даатгалд багтсан байгууллагад тогтмол ажил хийдэг бол таныг яс үндэс гарлыг үл харгалзан Ажилчдын Тэтгэмжийн Тогтолцоонд багтаах шаардлагатай. Хэрэв та одоогоор Япон улсад оршин сууж, байнгын бус ажил эрхэлдэг бол Үндэсний Тэтгэврийн Тогтолцоонд хамрагдах ёстой. Энэхүү тогтолцоо нь өндөр насны тэтгэвэр, тахир дутуу (үүнд тахир дутуугийн тэтгэвэр) эсвэл нас барсан тохиолдолд танд мөнгөн тусламж үзүүлж, сэтгэл хангалуун байх нөхцлийг бүрдүүлэх зарчимтай.

Хэрэв та хэдэн жилийн даатгалтай байж байгаад Японоос явж байгаа бол та зөвхөн японы бус иргэдэд олгох Бөөнөөр Олгох Төлбөрт хамрагдаж болно. *

Эсвэл таны яс үндэсийг үл харгалзаж та нийгмийн даатгалын хоёр талын зөвшилцөлөөс үүдсэн нийт ашиг авах өргөдөл гаргаж болно (Японы хувь тэнцүүлсэн ашиг ба/эсвэл гэрээлэгч улсын ашиг). Та Бөөнөөр Олгох Төлбөрт өргөдөл гаргасан бол таны бүх ашгийг авах хамрах хугацаа хязгаарлалттай гэдгийг санаж авна уу.

* [Жич] Таны Ажлын Тэтгэмжийн Даатгалаар тооцсон Бөөнөөр Олгох Төлбөрийн хугацаа татварт хамарна (2012 оны 12-р сард 20,42%, орлогын 20%-ийн татвар ба 0,42%-ийн гамшгийн дараах нөхөн олговорд зориулсан тусгай орлогын татвар үүнд орно). Та энэхүү татваруудын буцаан олголтыг нэхэж болно. Нарийвчлалыг Үндэсний Татварын Албаны вебсайтаас харна уу: www.nta.go.jp